

**САНГИЙН САЙД, МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2013 оны 5 дугаар
сарын 21-ны өдөр

Дугаар 111/А-105/131 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Засгийн газрын үнэт цаасыг хоёрдогч зах зээлд арилжих журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Сангийн яамны Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газар /Т.Доржханд/, Монголбанкны Валют, эдийн засгийн газар /Д.Дэлгэрсайхан/, Мөнгөний бодлого, судалгааны газар /Д.Болдбаатар/, Төлбөр тооцоо, бүртгэлийн газар /М.Амгалан/, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газар /Б.Саруул/, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 32/А-21 дүгээр хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тушаалын биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар/Б.Батцэцэг/, Монголбанкны Дотоод Хяналт, Үйл ажиллагааны Эрсдэлийн газар /Х.Дэлгэр/, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын алба/Х.Бум-Эрдэнэ/-нд тус тус үүрэг болгосугай.





- 1.1 Энэхүү журмын зорилго нь Засгийн газрын үнэт цаас /цаашид ЗГҮЦ гэнэ/-ны хоёрдогч зах зээлийн арилжаа, түүний шууд оролцогчийн үүрэг, хариуцлага, дотоод хяналт, хориглох үйл ажиллагаа, шууд оролцогч хооронд хийх арилжаа, шимтгэл, шууд бус оролцогчтой гэрээ байгуулах, өөрчлөх, цуцлах, дуусгавар болгох, түүнд мэдээлэл хүргэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 ЗГҮЦ-ны репо арилжаанд холбогдох үйл ажиллагааг Монголбанкны “Төв банкны овернайт репо санхүүжилтийн журам”, “Төв банкны репо арилжааны журам”, “Үнэт цаас буцаан худалдан авах нөхцөлтэй худалдах ерөнхий гэрээ”-гээр тус тус зохицуулна.
- 1.3 Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - 1.3.1 “ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3.1.9-д заасныг;
 - 1.3.2 “Оролцогч талууд” гэж ЗГҮЦ-ны хоёрдогч захын арилжаанд оролцож буй шууд оролцогч, шууд бус оролцогч, бүртгэгч болон Монголбанкныг;
 - 1.3.3 “Бохир үнэ” гэж ЗГҮЦ худалдан авагч талаас худалдагч талд төлж буй ЗГҮЦ-ны хуримтлагдсан хүүг агуулсан үнийг;
 - 1.3.4 “Цэвэр үнэ” гэж бохир үнээс ЗГҮЦ-ны хуримтлагдсан хүүг хассан үнийг;
 - 1.3.5 Энэ журамд хэрэглэгдэж буй бусад нэр томъёог Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 217/А-161 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжаалах журам”-ын 1.2-д заасныг.
- 1.4 ЗГҮЦ-ны хоёрдогч захын арилжаа нь дараах төрөлтэй байна:
 - 1.4.1 Шууд оролцогч нарын хооронд;
 - 1.4.2 Монголбанк, шууд оролцогч нарын хооронд;
 - 1.4.3 Шууд бус оролцогчийн захиалга биелүүлэх арилжаа.
- 1.5 Санхүүгийн зохицуулах хороо /цаашид Хороо гэнэ/-ны тусгай зөвшөөрөл бүхий шууд оролцогч нь шууд бус оролцогчийн болон өөрийн нэрийн өмнөөс ЗГҮЦ-ны хоёрдогч захын арилжаанд ороцно.
- 1.6 Шууд оролцогч нь өөрийн харилцагч шууд бус оролцогчийн эзэмшлийн ЗГҮЦ-ыг хоёрдогч зах зээл дээр худалдах/худалдан авах захиалгыг биелүүлэхээр гэрээ хийсэн тохиолдолд шууд оролцогч нь хийгдсэн хэлцлийн мэдээллийг нэн даруй цахим арилжааны системд оруулна.
- 1.7 Засгийн газрын бонд худалдах/худалдан авах хэлцлийг цэвэр үнээр, төлбөр тооцоог шууд оролцогчийн ЗГҮЦ-ны гүйлгээ хийх дансаар дамжуулан бохир үнээр хийнэ.
- 1.8 Хэлцлийн төлбөр тооцоог арилжааны өдрөөс хойш ажлын хоёр өдрийн дараа (Т+2) гүйцэтгэнэ.
- 1.9 ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаанд оролцож буй шууд бус оролцогч нь Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв /цаашид “ҮЦТТХТ” ХХК гэнэ/ ХХК-ийн төвлөрсөн хадгаламжид данстай байна.

- 1.10 Цахим арилжааны системээр дамжин хийгдсэн ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн хэлцлийн мэдээллийг Монголбанк тухайн өдөрт /T+0/ багтаан “ҮЦТТТХТ” ХХК-д цахим арилжааны системээр дамжуулан хүргүүлнэ.
- 1.11 “ҮЦТТТХТ” ХХК нь уг мэдээллийг төвлөрсөн хадгаламж дахь харилцагчийн мэдээлэлтэй тулгаж мэдээлэл зөрсөн, эсвэл данс нээгдээгүй байх, хэлцлээр худалдаж буй ЗГҮЦ-ны эзэмших эрхийн маргаантай тохиолдолд Монголбанкинд дараагийн өдрийн /T+1/ 12:00 цагаас өмнө мэдэгдэнэ.
- 1.12 Монголбанк нь төлбөр тооцоо хийгдсэн хэлцлийн мэдээллийг төлбөр тооцооны өдрийн /T+2/ 16:00 цагаас өмнө цахим арилжааны системээр дамжуулан “ҮЦТТТХТ” ХХК-д хүргүүлэх бөгөөд уг мэдээлэлд үндэслэн төлбөр тооцооны өдрийн 17:00 цагаас өмнө “ҮЦТТТХТ” ХХК өмчлөх эрхийг шилжүүлэн бүртгэл хийнэ.
- 1.13 Монголбанк нь цахим арилжааны системээр арилжаалагдсан ЗГҮЦ-ны нэгдсэн мэдээллийг тогтмол үүсгэнэ.

Хоёр. Шууд оролцогчийн үүрэг

- 2.1 Шууд оролцогч нь шууд бус оролцогчийн эрх ашгийг хамгаалах, зах зээлийн шударга байдлыг хангах үүднээс дараах үүрэгтэй. Үүнд:
 - 2.1.1 Холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах;
 - 2.1.2 Үйл ажиллагаагаа шударгаар явуулах;
 - 2.1.3 Шууд бус оролцогчийг ЗГҮЦ-ыг худалдах, худалдан авах шийдвэр гаргахад шаардлагатай үнэн зөв мэдээллээр хангах;
 - 2.1.4 Шууд бус оролцогчтой сонирхлын зөрчил үүсгэхгүй байх, үүссэн тохиолдолд түүнд мэдэгдэх;
 - 2.1.5 ҮЦТТТХТ ХХК-ийн төвлөрсөн хадгаламжид данстай шууд бус оролцогчийн захиалгыг хүлээн авах;
 - 2.1.6 ЗГҮЦ-ны репо арилжаанаас бусад тохиолдолд шууд бус оролцогчийн захиалгыг цахим арилжааны системд түрүүлж оруулах;
 - 2.1.7 Шууд оролцогч болон шууд бус оролцогчийн саналын өгөөж, ханш ижил тохиолдолд шууд бус оролцогчийн саналыг түрүүж биелүүлэх;
 - 2.1.8 Шууд бус оролцогч нарын саналын өгөөж, ханш ижил тохиолдолд цахим арилжааны системд оруулсан цаг хугацааны дарааллаар биелүүлэх.

Гурав. Шууд оролцогчийн хориглох үйл ажиллагаа

- 3.1 Шууд оролцогч нь дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:
 - 3.1.1 Шууд бус оролцогчид ЗГҮЦ, түүний арилжааны талаарх хуурамч мэдээллийг өгөх, төөрөгдүүлэх;
 - 3.1.2 Дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцох;
 - 3.1.3 ЗГҮЦ-ны үнэ ханшийг зохиомлоор тогтоон барих, өсгөх, бууруулах үйлдэл хийх;
 - 3.1.4 ЗГҮЦ-ны арилжааны явцад өмчлөгч нь өөрчлөгдөөгүй буюу нэгдмэл сонирхолтой этгээдийн хооронд тухайн үнэт цаасны үнэ, ханшийг зохиомлоор өсгөх, бууруулах зорилгоор хуурамч гүйлгээ хийх, ЗГҮЦ-ны арилжаа идэвхтэй явагдаж байгаа мэтээр олон нийтийг төөрөгдүүлэх зорилгоор давхар гүйлгээх хийх;
 - 3.1.5 Шууд бус оролцогчийн өмчлөлд байгаа ЗГҮЦ-ны тоо хэмжээ, түүнтэй холбогдох нийтэд тараагдаагүй мэдээллийг мэдээлэх, өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр сонирхогч этгээдэд уг үнэт цаасыг худалдан авахыг санал болгох, гүйлгээ хийх, мөнгөн хөрөнгийг ашиглах;
 - 3.1.6 Биелүүлэх зорилгогүйгээр их хэмжээний захиалга оруулах, түүнд олон дахин засвар хийх, цахим арилжааны системд нэг захиалгыг олон хэсэг хувааж оруулах үйлдэл хийх;

Дөрөв. Шууд бус оролцогчтой байгуулах гэрээ

- 4.1 Шууд оролцогч нь ЗГҮЦ-ыг худалдах, худалдан авахад зуучлах үйлчилгээнд холбогдох нөхцлийг агуулсан гэрээг шууд бус оролцогчтой байгуулах бөгөөд гэрээнд дараах заалтуудыг оруулахыг хориглоно:
- 4.1.1 Шууд оролцогчийн хууль бус үйл ажиллагааны улмаас шууд бус оролцогчид хохирол учруулснаас үүсэх хариуцлагыг хязгаарласан зохицуулалт;
 - 4.1.2 Шууд оролцогчийн хууль бус үйл ажиллагааны улмаас харилцагчид учирсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн дээд хэмжээг заасан зохицуулалт;
 - 4.1.3 Шууд бус оролцогчийн хууль тогтоомж болон гэрээнд заасан эрхээ хэрэгжүүлэх, гэрээг цуцлах эрхийг хязгаарлах, эсхүл хэт давуу тал олгосон зохицуулалт;
 - 4.1.4 Иргэний хуулийн 198.1 дэх заалтын дагуу үгийн шууд утгаар харилцагчид ойлгогдох боломжгүй, маргаан гарсан тохиолдолд өөрт ашигтайгаар хэд хэдэн утгаар тайлбарлах боломжтой заалт.

Тав. Шууд оролцогч нарын хооронд хийх ЗГҮЦ-ны арилжаа

5.1 Шууд оролцогч нь өөрийн болон шууд бус оролцогчийн эзэмшлийн ЗГҮЦ-ыг худалдах/худалдан авах саналыг цахим арилжааны системд оруулах ба хэлцлийг тухайн өдрийн 17:00 цагаас өмнө уг системээр хийнэ.

5.2 ЗГБХҮЦ-ыг худалдах/худалдан авах саналд дараах мэдээллийг багтаасан байна:

- 5.2.1 Үнэт цаасны төрөл, хугацаа;
- 5.2.2 Арилжаалах үнэт цаасны тоо ширхэг;
- 5.2.3 Олон улсын үнэт цаасны бүртгэлийн дугаар (ISIN);
- 5.2.4 Үнэт цаасны хугацаа дуусах огноо;
- 5.2.5 Төлбөр тооцоо хийх өдөр;
- 5.2.6 Үнэт цаасны өгөөжийн хувь;
- 5.2.7 ЗГБХҮЦ худалдах/худалдан авах нэгж үнэ;
- 5.2.8 ЗГБХҮЦ худалдах/худалдан авах нийт үнэ;
- 5.2.9 ЗГБХҮЦ-ны эзэмшигчийн мэдээлэл;
- 5.2.10 Саналын хүчинтэй байх хугацаа. /Огноо, цаг, минут/

5.3 Засгийн газрын бондыг худалдах/худалдан авах саналд дараах мэдээллийг багтаасан байна:

- 5.3.1 Төрөл, хугацаа;
- 5.3.2 Арилжаалах үнэт цаасны тоо ширхэг;
- 5.3.3 Олон улсын үнэт цаасны бүртгэлийн дугаар (ISIN);
- 5.3.4 Үнэт цаасны хугацаа дуусах огноо;
- 5.3.5 Төлбөр тооцоо хийх өдөр;
- 5.3.6 Купоны хувь хэмжээ;
- 5.3.7 Купон төлбөр давтамж, купон төлөх огноо;
- 5.3.8 Үнэт цаасны өгөөжийн хувь;
- 5.3.9 Засгийн газрын бондыг худалдах/худалдан авах нэгж үнэ;
- 5.3.10 Засгийн газрын бондыг худалдах/худалдан авах нийт үнэ;
- 5.3.11 Засгийн газрын бондыг эзэмшигчийн мэдээлэл;
- 5.3.12 Саналын хүчинтэй байх хугацаа. /Огноо, цаг, минут. Санал 30 хоноогоос илүүгүй хугацаанд хүчинтэй байна./

5.4 ЗГҮЦ-ны эзэмшигчийн мэдээлэл нь дараах бүрдүүлбэртэй байх ба мэдээллийн үнэн зөвийг системд оруулсан шууд оролцогч бүрэн хариуцна:

- 5.4.1 Хуулийн этгээд бол аж ахуйн нэгжийн оноосон нэр, хувь хүн бол ургийн овог, овог, нэр;
- 5.4.2 Хуулийн этгээд бол аж ахуйн нэгжийн бүртгэлийн, хувь хүн бол регистрийн дугаар;

- 5.4.3 Хуулийн этгээд бол төв байрны хаяг, хувь хүн бол гэрийн хаяг
 - 5.4.4 Банкин дахь үнэт цаасны арилжаа хийх дансны дугаар;
 - 5.4.5 “ҮЦТТХТ” ХХК дахь дансны дугаар.
- 5.5 Техникийн саатлаас шалтгаалан цахим арилжааны системд хэлцлийн мэдээллийг оруулах боломжгүй тохиолдолд шууд оролцогч нь хийсэн хэлцлийн материалыг 17:00 цагаас өмнө Монголбанкинд биечлэн хүргүүлж, хийгдсэн хэлцлийн мэдээллийг дараа өдрийн 12:00 цагаас өмнө цахим арилжааны системд оруулсан байна.
- 5.6 Монголбанк хэлцэлд заасан төлбөр тооцооны өдөр арилжааны төлбөр тооцоог 15:00 цагаас өмнө гүйцэтгэж, төлбөр төлсөн эзэмшигчийн мэдээллийг “ҮЦТТХТ” ХХК-д цахим арилжааны системээр илгээнэ.

Зургаа. Монголбанк, шууд оролцогч нарын хооронд хийх ЗГҮЦ-ны арилжаа

- 6.1 Мөнгөний бодлогын зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монголбанк ЗГҮЦ-ыг хоёрдогч зах дээр худалдаж/худалдан авч болно.
- 6.2 Монголбанк, шууд оролцогч хооронд хийгдэх ЗГҮЦ-ны хоёрдогч захын арилжаа нь дараах хэлбэртэй байна.
- 6.2.1 Шууд оролцогчийн саналыг биелүүлэх;
 - 6.2.2 Монголбанкнаас арилжааг зарлах.
- 6.3 Цахим арилжааны системд оруулсан шууд оролцогчийн ЗГҮЦ худалдах/худалдан авах саналыг биелүүлэх замаар энэ журмын 6.2.1-д заасан арилжааг хийнэ.
- 6.4 Энэ журмын 6.2.2-д заасан арилжаа нь дараах хэлбэртэй байна.
- 6.4.1 Монголбанк арилжааны хэмжээг тодорхойлж, шууд оролцогч нь ЗГҮЦ-ны өгөөж, худалдах/худалдан авах үнэ болон хэмжээний санал ирүүлэх;
 - 6.4.2 Монголбанк арилжааны хэмжээ, худалдах/худалдан авах ЗГҮЦ-ны өгөөж, үнийг тодорхойлж, шууд оролцогч худалдах/худалдан авах хэмжээний санал ирүүлэх.
- 6.5 Монголбанк нь энэ журмын 6.2.2-д заасан арилжааны мэдэгдлийг шууд оролцогчдоод ажлын нэг өдрийн 14:00 цагаас өмнө цахим арилжааны системээр, эсвэл факс, цахим шуудангаар хүргүүлэх ба арилжааны мэдэгдэлд дараах мэдээллийг багтаасан байна:
- 6.5.1 Арилжааны дугаар;
 - 6.5.2 ЗГҮЦ-ны төрөл;
 - 6.5.3 Арилжааны өдөр;
 - 6.5.4 Арилжааны санал хүлээж авах цаг;
 - 6.5.5 Арилжааны хэлбэр;
 - 6.5.6 Төлбөр тооцооны өдөр;
 - 6.5.7 Арилжааны хэмжээ;
 - 6.5.8 Худалдах/худалдан авах ЗГҮЦ-ны өгөөж;
 - 6.5.9 Худалдах/худалдан авах нэгж ЗГҮЦ-ны үнэ;
- 6.6 Монголбанк шууд оролцогчдоос шаардлага хангасан саналыг хүлээн авч дараах зарчмын дагуу хуваарилна.
- 6.6.1 Энэ журмын 6.4.1-д заасан хэлбэрээр арилжааг зохион байгуулсан, Монголбанк ЗГҮЦ худалдан авах тохиолдолд шууд оролцогчдоос ирүүлсэн өгөөжийн саналыг жагсаан, хамгийн өндөр хүүний саналаас эхлэн зарласан арилжааны хэмжээ хүртэл хуваарилах бөгөөд Монголбанк ЗГҮЦ худалдах тохиолдолд хамгийн бага хүүгийн саналаас эхлэн зарласан арилжааны хэмжээ хүртэл хуваарилна.

- 6.6.2 Ижил хүүний санал ирүүлсэн тохиолдолд “ЗГҮЦ гаргах, арилжаалах журам”-ын 3.24.8-д заасны дагуу.
- 6.6.3 Энэ журмын 6.4.2-д заасан хэлбэрээр арилжааг зохион байгуулсан, шууд оролцогчдын ирүүлсэн саналын хэмжээ арилжааны мэдэгдэлд зарласан хэмжээнээс давсан тохиолдолд “ЗГҮЦ гаргах, арилжаалах журам”-ын 3.24.8-д заасны дагуу.
- 6.7 Монголбанк нь арилжааны үр дүнг төлбөр тооцооны өдрийн 16:00 цагаас өмнө “ҮЦТТТХТ” ХХК-д цахим арилжааны системээр хүргүүлэх бөгөөд “ҮЦТТТХТ” ХХК нь төлбөр тооцооны өдөрт багтаан ЗГҮЦ-ны эзэмшлийн эрхийг шилжүүлж бүртгэнэ.

Долоо. Саналыг өөрчлөх, цуцлах, дуусгавар болгох

- 7.1 ЗГҮЦ-ыг хоёрдогч зах зээлд худалдах, худалдан авах саналыг тухайн арилжааны явцад хэлцэл хийгдэхээс өмнө өөрчилж, цуцалж болно.
- 7.2 Дараах тохиолдолд захиалгад өөрчлөлт оруулна:
- 7.2.1 Шууд бус оролцогч ЗГҮЦ-ны арилжааны явцад нэг буюу түүнээс дээш өдрийн туршид захиалга биелүүлэхгүй байхаар мэдэгдсэн;
- 7.2.2 Шууд бус оролцогч ЗГҮЦ-ны худалдах буюу худалдан авах үнийг өөрчлөхөөр мэдэгдсэн;
- 7.2.3 Шууд бус оролцогч худалдах, худалдан авах ЗГҮЦ-ны тоо ширхэгт өөрчлөлт оруулахаар мэдэгдсэн.
- 7.3 Саналд өөрчлөлт оруулахад саналын хүчинтэй байх хугацаа өөрчлөгдөхгүй.
- 7.4 Шууд бус оролцогч саналыг биелүүлэх явцад түүнийг цуцлахыг хүсвэл энэ тухай шууд оролцогчид мэдэгдэх ба шууд оролцогч нь энэ талаар холбогдох анхан шатны баримтад тэмдэглэнэ.
- 7.5 Шууд бус оролцогч нь саналаа өөрчлөх, цуцлахдаа санал өгсөн арга хэлбэрээр, эсхүл шууд оролцогчийн дотоод журмын дагуу бусад санал өгөх арга хэлбэрээр өөрчилж, цуцална.
- 7.6 Санал нь дараах тохиолдолд дуусгавар болно:
- 7.6.1 Саналыг бүрэн биелүүлсэн;
- 7.6.2 Саналын хугацаа дууссан.

Найм. Шууд оролцогчийн үйл ажиллагааны шимтгэл

- 8.1 Шууд оролцогч нь шууд бус оролцогчид үзүүлсэн үйлчилгээндээ дотоод журмын дагуу шимтгэл авч болох бөгөөд Хорооны тогтоолд заасан зохицуулах үйлчилгээний шимтгэлийг Хороонд төлнө.
- 8.2 Шууд оролцогч нь шимтгэлийг тогтоохдоо тусгай нөхцөлтэй гэрээний хувьд өөрөөр тогтоож болох ба тухайн сарын шимтгэлийн мэдээг дараа сарын 05-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

Ес. Шууд бус оролцогчид мэдээлэл хүргэх

- 9.1 Шууд бус оролцогчтой гэрээ байгуулахын өмнө шууд оролцогч нь үнэт цаасны зах зээлийн тухай ойлголт өгөх зорилгоор дараах мэдээллийг заавал танилцуулсан байна:
- 9.1.1 Хэлцэл хийгддэг буюу арилжаа явагддаг үйл явц, механизм;
- 9.1.2 ЗГҮЦ-ыг худалдах, худалдан авахад хүлээж болох эрсдэл.

- 9.2 Шууд оролцогч нь шууд бус оролцогчийн өгсөн санал биелэгдсэн тохиолдолд түүнд ЗГҮЦ-ны код, хэлцэл хийгдсэн өдөр, үнэ, хэмжээ, шимтгэлийн талаарх мэдээллийг гэрээнд заасан цахим шуудан, утас, факс, бусад боломжит харилцаа холбооны хэрэгслээр мэдэгдэнэ.
- 9.3 Шууд оролцогч нь өөрийн дансны хуулгыг шалгах боломжоор шууд бус оролцогчийг хангана.
- 9.4 Шууд оролцогч нь шууд бус оролцогчийн шаардсанаар үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл болон улсын бүртгэлийн гэрчилгээ, санхүүгийн байдлын талаархи мэдээллийг өгөх үүрэгтэй.
- 9.5 Шууд оролцогч нь ЗГҮЦ-ыг худалдах болон худалдан авахад зуучлах үйлчилгээг санал болгож, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон утас, интернет, цахим шуудан, хэвлэмэл хуудсаар нийтэд зар сурталчилгаа явуулж болно.
- 9.6 Шууд оролцогч нь гуравдагч этгээдээс авсан аливаа үндэслэлтэй мэдээллийг ЗГҮЦ худалдах, худалдан авахыг санал болгох, нийтэд мэдээлэл хүргэх, зар сурталчилгаа явуулахдаа иш татаж ашиглана.

Арав. Дотоод хяналт

- 10.1 Шууд оролцогч нь үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон энэхүү журамд заасны дагуу дотоод хяналтын үйл ажиллагааг зохицуулах журамтай байх ба дотоод хяналтын үйл ажиллагаатай холбоотойгоор Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, дотоод хяналтын ажилтны үүрэг, хариуцлагыг тодорхой болгох үүрэгтэй.
- 10.2 Дотоод хяналт нь шууд оролцогчийн нягтлан бодох бүртгэл, эрсдлийн удирдлагын хяналтыг бүрэн хамаарч чадахуйц байх бөгөөд үйл ажиллагааны үе шат бүрт хяналт тавьж болохуйцаар зохион байгуулагдсан байна.
- 10.3 Дотоод хяналтыг тогтмол болон гэнэтийн шалгалтаар хэрэгжүүлэх ба дотоод хяналтын нэгж нь шалгалт бүрийн дараа тайлан, дүгнэлт гаргаж гүйцэтгэх удирдлагад тайлагнана.
- 10.4 Энэ журмын 10.3-т заасан хяналтыг хэрэгжүүлэх явцад тухайн ажилтан холбогдох хууль, тогтоомж зөрчсөн нь тогтоогдвол түүнийг албан тушаал эрхлэхийг яаралтай түдгэлзүүлэн Хороонд зөрчлийн талаар нэн даруй мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдэх үүргээ биелүүлээгүй бол тухайн зөрчлийг шууд оролцогч гаргасанд тооцно.

Арван нэг. Бичиг баримтыг хадгалах

- 11.1 Шууд оролцогч нь дараах бичиг баримтыг 5 жил /аливаа үүрэг үүсгэсэн баримт бичиг, тухайлбал гэрээ, шүүхийн шийдвэр, төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг тухайн үүрэг дууссанаас хойш/ хадгалах үүрэгтэй:
- 11.1.1 Шууд оролцогчийн үйл ажиллагаатай холбоотой бичиг баримт. Үүнд:
- а/ Шууд бус оролцогчтой байгуулсан данс нээх болон бусад холбогдох гэрээ;
 - б/ Шууд бус оролцогчийн ерөнхий мэдээллийн бүртгэл;
 - в/ ЗГҮЦ-ыг худалдах, худалдан авах шууд бус оролцогчийн саналтай холбоотой баримтууд;
 - г/ Шууд бус оролцогчийн үнэт цаасны арилжааны дансны мөнгөн хөрөнгийн гүйлгээтэй холбоотой баримтууд;
 - д/ Шууд бус оролцогчийн дансны шилжилт хөдөлгөөний бүртгэл, хэлцлийн мэдээлэл /ЗГҮЦ-ны хэлцлийн огноо, үнэ, шимтгэлийн хэмжээ/.
- 11.1.2 Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой бичиг баримт. Үүнд:
- а/ Холбогдох этгээд болон нэгдмэл сонирхолтой этгээдийн бүртгэл;
 - в/ Өөрийн данс дахь ЗГҮЦ-ны хэлцлийн бүртгэл;
 - г/ Холбогдох этгээдтэй хийсэн хэлцлийн бүртгэл.
- 11.1.3 Дотоод хяналтын үйл ажиллагаатай холбоотой бичиг баримт. Үүнд:

- а/ Дотоод хяналтын үйл ажиллагааны тайлан, дүгнэлт;
б/ Дотоод хяналтын тайлангийн үр дүнд хийгдсэн ажлын тайлан, холбогдох бичиг баримтууд.
- 11.1.4 Тусгай зөвшөөрлийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой бичиг баримт, гэрээ хэлцэл зэрэг бусад бичиг баримтууд.
- 11.2 Шууд оролцогч нь Хорооны улсын байцаагчийн шаардсанаар энэ журмын 11.1-д заасан бичиг баримтыг гаргаж өгөх ба харилцагчдын ЗГҮЦ-ны данс, шимтгэлийн мэдээлэл болон өөрийн үйл ажиллагааны товч тайланг улирал бүр Хороонд ирүүлэх үүрэгтэй.

Арванхоёр. Хариуцлага

- 12.1 Монголбанк ЗГҮЦ-ны хоёрдогч арилжааны явцад маргаан, зөрчил гарвал Хороонд тухай бүр мэдэгдэх бөгөөд арилжаанд оролцохтой холбоотой харилцаанд үүсэх аливаа маргааныг болон оролцогчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг Хороо хэрэгжүүлнэ.
- 12.2 Хороо нь шууд оролцогчийн үйл ажиллагаанд дараах хяналтыг хэрэгжүүлнэ:
- 12.2.1 Шууд бус оролцогчийн арилжааны санал хүлээн авах, биелүүлэх үйл ажиллагаа;
12.2.2 Шууд оролцогч болон түүний дотоод мэдээлэл эзэмшигчийн холбогдох гүйлгээ;
12.2.3 Энэ журам болон холбогдох бусад хууль тогтоомж, журам зааврын хэрэгжилт.
- 12.3 Хорооноос ээлжит болон цаг үеийн шалгалтыг дараах хэлбэрээр явуулна:
- 12.3.1 Газар дээрх шалгалт хийх;
12.3.2 Шаардлагатай баримт бичиг, тайлан мэдээллийг авч баримтын шалгалт хийх.
- 12.4 Улсын байцаагч нь шалгалтын дүнг үндэслэн акт тогтоох, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар хугацаатай үүрэг өгөх, зөрчилтэй нь нотлогдвол тухайн арилжааны хэлцлийг хүчингүй болгох, хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 18.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгаагүй, захиргааны шийтгэлтэйд тооцогдох хугацаанд дахин зөрчил гаргасан тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг Хорооны хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлнэ.
- 12.5 Шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдал нь зах зээлийн хэвийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр бол зөрчил, түүнд авсан арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлнэ.
- 12.6 Хэрэв шууд болон шууд бус оролцогч нь улсын байцаагчийн тогтоосон актыг хүлээн зөвшөөрөхгүй бол шүүх, эрх бүхий байгууллагад хандаж гомдол гаргаж болно.
- 12.7 Хэлцлийн дагуу төлбөр тооцоо хийгдээгүй тохиолдолд дараах арга хэмжээг авна. Үүнд:
- 12.7.1 Хэлцэлд заасан төлбөр тооцооны өдөр ЗГҮЦ худалдан авах бохир үнийг бүрэн шилжүүлээгүй тохиолдолд худалдан авагч талын шууд оролцогчийн Монголбанк дахь харилцах данснаас төлбөрийг үл маргах журмаар суутгаж төлүүлнэ.
12.7.2 Хэлцлийн төлбөрөө давтан төлөөгүй оролцогчид Хорооноос Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан арга хэмжээг авна.